




29 Page



30 Page



31 Page



32 Page

Бабел цамхаг

-The Tower of Babel-

Тайлбарлагч Ноагийн үерээс хойш их цаг хугацаа өнгөрөв. Дэлхий дээр Ноагийн үр удам олширч, хамтдаа амьдарцгааж, бүгд нэг хэлээр ярьдаг байлаа. Тэд дорно зүг уруу нүүж, Шинар газрын нэгэн талд хамтдаа нутаглан суух болжээ.

Эрэгтэй хүн За, юу байна даа, анар жимс их зарагдаж байна уу?

Шар малгайтай эмэгтэй За, тайван тайван! Сайн зарагдахгүй болохоор их байгаа биз дээ! Хахаха (Хүмүүсийн шуугилдах чимээ)

Тайлбарлагч Хүмүүс олуулаа амьдарч байсан учир тосгон ч аажмаар томорч эхэлжээ. Тоосгоор бат бөх гэр барьцгааж, идэх хүнсээр ч элбэг хангалуун байцгаалаа.

Ягаан хувцастай хүн Бүгдээрээ тоосгоор маш том хот цамхаг барьж үзэх үү?

Тайлбарлагч Хүмүүс ухаантай болох тусам Бурханыг тоохгүй амьдрах болов. Тэд харин ч өөрсдөө Бурхан шиг болохыг бодож эхэлжээ.

Эрэгтэй хүн "Дэлхий дээрх хамгийн өндөр цамхаг барьцгаая" Энэ цамхаг л байх юм бол бид ямар ч айх аюулгүйгээр сайхан амьдрах болно. Тэгээд цамхаг өндөр барьвал Бурхан шиг өндөрт өргөмжлөгдөх болно."

Улаан эмэгтэй "Зөв, зөв, ингэж чадвал Бурхан биднийг дураараа шийтгэж чадахгүй байх!"

Тайлбарлагч Бага багаар шуналтай болж байгаа хүмүүс маш өндөр цамхаг барьж эхэлжээ.

Хүмүүс "Өндөр, бүр өндрийг барьцгаая!" Уухайс уухайс, хүчтэй байгаарай! Тэнгэр ойрхон харагдаж байна. Уухайс уухайс!

Тайлбарлагч Хүмүүс энэ цамхгийг барихаасаа өмнө Бурханаас ч асуулгүйгээр өөрсдөдөө таалагдахаар барьж эхлэв. Хүмүүс бардам болж, Бурханыг хүндэтгэх сэтгэлгүй болсон байлаа. Өдөр ирэх тусам цамхаг өндөр болсоор байв. Бурхан хүмүүсийн барьж байгаа цамхгийг харжээ. Тэр цамхаг Бурханд таалагдсангүй. Тиймээс Бурхан тэднийг нэг болгохгүйн тулд тэдний хэлийг өөр өөр болгон сольж хутгалдуулан орхижээ.

Хүн1 "Алх аваад өгдөө!"

Хүн2 "What did you say?"

Хүн1 "Юу гээд байгаа юм бэ?" Алх аваад өгөөдөх өө."

Хүн3 Ваагаа вагаа гүү гүү?

Хүн4 Хоруллу хуру руллу

Хүн5 Үгүй ер нь юу гэгцгээгээд байгаан бэ? Гэнэт яагаад байгаа юм бэ?

Хүн6 Бү hao! Бү hao! Нани??Нани??



33 Page

Тайлбарлагч Хүмүүс бие биенийхээ хэлийг ойлгохгүй байлаа. Бие биенээ буруу ойлголцож байсан тул ихэд үймэцгээн хамтдаа амьдрах боломжгүй болжээ. Тэнгэрт тултал барьж байсан цамхгаа орхин тус тусын замаараа явцгаажээ. Ийм сонин гайхалтай зүйл болсонд тэд, Бурхан хүч чадалтай нэгэн болохыг мэдэж авчээ. Тэгээд хамтдаа барьж байсан цамхгаа “Бабел” гэж нэрлэжээ. ЭЗЭН тэднийг тэндээс бүх дэлхий даяар тараасан билээ.